



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/20/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
Аудитаар 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн алт тогтоов. Үүнд: .....	15
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**АЛТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ч.ГЭРЭЛТУЯА ТАНАА**

2022.02.05 № 181  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>26,957,692.45</u></b>	<b><u>28,619,546.45</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	26,957,692.45	28,619,546.45
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,092,100.00	5,082,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,088,500.00	4,945,000.00
35130	Эм боох материал	3,600.00	137,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	23,865,592.45	23,537,546.45
35410	Бичиг хэргийн материал	434,980.00	720,000.00
35420	Аж ахуйн материал	10,942,070.00	10,123,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	6,709,626.00	1,396,600.00
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	2,509,816.45	6,944,186.45
35470	Бусад хангамжийн материал	3,269,100.00	4,353,310.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>629,987,939.01</u></b>	<b><u>618,927,478.38</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	629,987,939.01	618,927,478.38
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	622,533,939.01	611,473,478.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	574,584,446.62	582,584,446.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,359,469.38)	(66,133,059.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,243,608.00	80,501,952.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,107,073.72)	(20,729,620.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,867,809.00	36,047,809.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,604,950.51)	(8,669,718.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	300,000.00	300,000.00
39217	Ном	6,609,569.00	7,571,669.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,454,000.00	7,454,000.00
39301	Програм хангамж	383,500.00	383,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(383,500.00)	(383,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,454,000.00	7,454,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>656,945,631.46</u></b>	<b><u>647,547,024.83</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>656,945,631.46</u></b>	<b><u>647,547,024.83</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	656,945,631.46	647,547,024.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	51,413,284.00	51,413,284.00
51101	Өмч: - төрийн	51,413,284.00	51,413,284.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	520,968,263.84	511,569,657.21
51210	Өмнөх үеийн үр дүн	520,968,263.84	520,968,263.84
51220	Тайлант үеийн үр дүн		(9,398,606.63)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,564,083.62	84,564,083.62
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>656,945,631.46</u></b>	<b><u>647,547,024.83</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>218,911,063.00</b>	<b>241,867,425.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,073,126.00</b>	<b>4,383,210.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,073,126.00	4,383,210.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,073,126.00	4,383,210.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,073,126.00	4,383,210.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>212,837,937.00</b>	<b>237,484,215.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	189,854,315.00	211,663,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	9,451,015.00	8,275,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	180,403,300.00	203,388,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,000,000.00	2,136,015.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	2,136,015.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	13,228,271.00	20,294,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,228,271.00	12,294,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/		8,000,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	7,755,351.00	3,391,000.00
133003	Хөрөнгийн	7,755,351.00	3,391,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>216,568,148.43</b>	<b>250,294,831.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>216,568,148.43</b>	<b>250,294,831.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	210,571,108.43	249,315,626.63
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	134,001,886.12	152,546,326.00
210101	Үндсэн цалин	119,499,341.51	141,690,336.00
210104	Урамшуулал	10,564,744.61	6,318,190.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,937,800.00	4,537,800.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,248,517.78	18,493,074.00
210201	Тэтгэврийн даатгал	11,265,632.17	12,417,974.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,261,000.00	1,506,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	953,577.71	1,205,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	190,375.00	301,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,577,932.90	3,061,200.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,390,188.95	16,611,746.00
210301	Гэрэл, цахилгаан	150,000.00	218,300.00
210302	Түлш, халаалт	12,240,188.95	16,181,946.00
210303	Цэвэр, бохир ус		211,500.00
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,410,220.00	6,846,120.00
210401	Бичиг хэрэг		299,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,830,120.00	3,280,980.00

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	580,100.00	657,500.00
210404	Ном, хэвлэл		40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,567,840.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,556,697.15	21,201,525.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,250.00	239,000.00
210502	Хоол, хүнс	9,435,047.15	20,857,025.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,052,400.00	105,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	167,200.00
210604	Урсгал засвар		167,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	302,900.00	78,300.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	302,900.00	78,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	378,500.00	358,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		12,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	378,500.00	345,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	30,282,198.43	33,013,135.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	381,770.00	2,206,575.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,900,428.43	30,806,560.63
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,997,040.00	979,205.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,996,200.00	979,205.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,996,200.00	979,205.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,000,840.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,000,840.00	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>2,342,914.57</u></b>	<b><u>(8,427,406.63)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	2,871,932.00	971,200.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,871,932.00	971,200.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(2,871,932.00)	(971,200.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(529,017.43)</u></b>	<b><u>(9,398,606.63)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,959,284.00	16,107,743.00	(2,671,073.82)		57,395,953.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,959,284.00	16,107,743.00	(2,671,073.82)		57,395,953.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			4,628,428.40		4,628,428.40
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,959,284.00	16,107,743.00	1,957,354.58		62,024,381.58
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,959,284.00	16,107,743.00	6,585,782.98		66,652,809.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,454,000.00	68,456,340.62	520,968,263.84		596,878,604.46
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	51,413,284.00	84,564,083.62	520,968,263.84		656,945,631.46
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(9,398,606.63)		(9,398,606.63)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,413,284.00	84,564,083.62	511,569,657.21		647,547,024.83

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>195,631,571.00</b>	<b>217,818,115.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>195,631,571.00</b>	<b>217,818,115.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>180,403,300.00</b>	<b>203,388,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	180,403,300.00	203,388,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,136,015.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	2,136,015.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>13,228,271.00</b>	<b>12,294,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,228,271.00	12,294,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>193,945,571.00</b>	<b>217,738,115.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>193,945,571.00</b>	<b>217,738,115.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>187,169,931.00</b>	<b>211,910,615.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>127,422,875.12</b>	<b>150,695,500.00</b>
210101	Үндсэн цалин	112,957,760.12	137,672,900.00
210104	Урамшуулал	9,927,315.00	8,484,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,537,800.00	4,537,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,211,584.88</b>	<b>20,343,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,151,332.17	14,316,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,306,200.00	1,506,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	950,877.71	1,205,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	190,375.00	301,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,612,800.00	3,013,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,228,271.00</b>	<b>11,794,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	611,100.00	864,000.00
210302	Түлш, халаалт	10,592,171.00	9,430,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,025,000.00	1,500,000.00

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,287,900.00	3,985,800.00
210401	Бичиг хэрэг	222,100.00	68,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,831,200.00	2,913,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	552,000.00	657,500.00
210404	Ном, хэвлэл	145,400.00	17,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	537,200.00	328,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,443,400.00	21,177,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,500.00	220,400.00
210502	Хоол, хүнс	10,238,900.00	20,443,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,134,000.00	514,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	500,000.00
210604	Урсгал засвар		500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	302,900.00	78,300.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	302,900.00	78,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	450,000.00	497,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		97,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,823,000.00	2,837,715.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,823,000.00	2,837,715.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,775,640.00</b>	<b>5,827,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,774,800.00	5,827,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,774,800.00	5,827,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,000,840.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,000,840.00	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,686,000.00</u></b>	<b><u>80,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,686,000.00</b>	<b>80,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,686,000.00</b>	<b>80,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,686,000.00	80,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,686,000.00	80,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,686,000.00)</u></b>	<b><u>(80,000.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	215,682,100.00	215,682,100.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	215,682,100.00	215,682,100.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	209,854,600.00	209,854,600.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	150,695,500.00	150,695,500.00
210101	Үндсэн цалин	137,672,900.00	137,672,900.00
210104	Урамшуулал	8,484,800.00	8,484,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,537,800.00	4,537,800.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,343,900.00	20,343,900.00
210201	Тэтгэврийн даатгал	14,316,100.00	14,316,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,506,900.00	1,506,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,205,600.00	1,205,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	301,400.00	301,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,013,900.00	3,013,900.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,794,000.00	11,794,000.00
210301	Гэрэл, цахилгаан	864,000.00	864,000.00
210302	Түлш, халаалт	9,430,000.00	9,430,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
210304	Байрны түрээс		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,065,800.00	4,065,800.00
210401	Бичиг хэрэг	68,500.00	68,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,913,800.00	2,913,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	657,500.00	657,500.00
210404	Ном, хэвлэл	97,900.00	97,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	328,100.00	328,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	<b>Нормативт зардал</b>	21,037,500.00	21,037,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,400.00	80,400.00
210502	Хоол, хүнс	20,443,100.00	20,443,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	514,000.00	514,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	78,300.00	78,300.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	78,300.00	78,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	497,900.00	497,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,900.00	97,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	841,700.00	841,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	841,700.00	841,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,827,500.00	5,827,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,827,500.00	5,827,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,827,500.00	5,827,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	215,682,100.00	215,682,100.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	203,388,100.00	203,388,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	203,388,100.00	203,388,100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	12,294,000.00	12,294,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	12,294,000.00	12,294,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	15.00	15.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	41.00	40.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	41.00	40.00
630001	Төрийн өмчит ЕБС	41.00	40.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>15.00</b>	<b>15.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	7.00	7.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,136,015.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,136,015.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,000,000.00	2,136,015.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	140,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		140,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,000,000.00	1,996,015.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,996,015.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	2,136,015.00

1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	2,136,015.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,136,015.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь суралцагчид нь ерөнхий боловсролын суурь мэдлэг, чадварыг эзэмшсэн, бие даан сурах, амьдрах чадвартай, эрүүл чийрэг, ЗӨВ МОНГОЛ хүүхэд болгон төлөвшсөн, хүний нөөцөөр бүрэн хангагдсан, санхүүгийн хувьд зөрчилгүй ажилласан, гадаад дотоод орчноо бүрдүүлсэн сургууль байхад оршино гэсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажилладаг бөгөөд тайлант онд тус байгууллагад шалгалт хийгдээгүй байна

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 221.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.4 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	26,957.7	28,619.5	1,661.8
Үндсэн хөрөнгө	629,987.9	618,927.5	-11,060.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>656,945.6</b>	<b>647,547.0</b>	<b>-9,398.6</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	656,945.6	647,547.0	-9,398.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>656,945.6</b>	<b>647,547.0</b>	<b>-9,398.6</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, өглөгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28.6 сая төгрөг болж өмнөх оноос 1.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 45.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 46.8 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Мөн 3.4 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, 1.0 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг Улаанбаатар хотод байгаа нутгийн иргэд хандивласныг данс бүртгэлд орлогод авч, Алтай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 35

дугаар тогтоолоор 1.0 сая төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 618.9 сая төгрөг болж 9.4 сая төгрөгөөр буурсан байна. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 8.0 сая төгрөгийн 400 м2 модон сараалж хашаа, БШУЯамны хөрөнгө оруулалтаар 3.4 сая төгрөгийн сансрын интернэтийн төхөөрөмж, Швейцар Улсын “Сайхан Монголын өнгө” ТББ-аас 4.2 сая төгрөгийн интернэтийн төхөөрөмж, 3.2 сая төгрөгийн тавилга эд хогшлыг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд бүртгэсэн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 133 дугаар тогтоолоор элэгдлээ бүрэн нөхсөн 4.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 6.0 сая төгрөгийн тавилгыг акталж данс бүртгэлээс хассан байна. Тайлант онд үндсэн хөрөнгөд 30.8 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 647.5 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 9.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв нь 184.0 сая төгрөг ба 215.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Анх баталсан төсвийг 31.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон нь цалингийн зардлыг 36.6 сая төгрөгөөр, НДШ-ийг 4.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 9.0 сая төгрөгөөр, үдийн хоолны зардлын төсвийг 0.9 сая төгрөгөөр бууруулж тодотгосонтой холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 215.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 215.7 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа бүрэн зарцуулсан байна.

Нийт төсвийн 70 хувийг цалин, 9.4 хувийг НДШ-ийн зардал, 5.5 хувийг тогтмол зардал, 1.8 хувийг хангамж бараа материалын зардал, 9.7 хувийг норматив зардал, 0.2 хувийг урсгал засварын зардал, 0.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд аймгийн БСУГаараас 2.1 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт дансаар хүлээн авч 0.1 сая төгрөгийг ариутгалын бодис, 2.0 сая төгрөгийг “Миний орчин-миний хичээл” хөтөлбөрийн арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан ба АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 100 хувь буюу 149 мэдээллийг хуулийн хугацаандаа бүрэн байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар хүүхдийн хоол, хүнсний материалыг бодит хэрэгцээнд үндэслэн худалдан авалт хийх, гарч болох эрсдэлийг урьдчилан тооцож, чанар байдлаа алдаж муудахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг сургуулийн захирлын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлжээ.

Гарсан зөрчлийг арилгаж шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж, хоол, хүнсний материалыг бодит хэрэгцээнд үндэслэн худалдан авалт хийсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Цалингаас суутгах хувь хүний орлогын албан татварын ногдуулалт, төлөлтийн тооцоог шалгаж үзэхэд тайлант онд олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод 10.2 сая төгрөгийн татвар ногдуулж, 9.5 сая төгрөгийг шилжүүлж, 0.7 сая төгрөгийн татварыг дутуу төлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, ХХОАТ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос 10 хувиар тооцож албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт дутуу төлсөн татварыг сургуулийн төсвөөс нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан	Нийт алдаа, зөрчлийн	Үүнээс			
			Залруулга	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

	байгууллагын нэр	Тоо	Дүн								
1	Алтай сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	1	0.7			1	0.7				